



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/05

Улаанбаатар хот

“Бүргэдийн баяр-2024” арга хэмжээ
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 458 дугаар тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 122 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны А/180 дугаар захирамж, нийслэлийн Засаг даргын 2022 оны 155 дугаар захирамжаар батлагдсан газрын дүрмийн 4.1.10, 7.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол улсын Засгийн газраас 2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, Улаанбаатар хотод зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор “Бүргэдийн баяр 2024” арга хэмжээг Чингис Хааны Хүрээ аялал жуулчлалын цогцолборт 2024 оны 03 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Арга хэмжээний удирдамжийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 20,500,000₮ (Хорин сая, тавин мянга) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (Д.Уянга)-д зөвшөөрсүгэй.


4. Арга хэмжээ зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс (С.Туул)-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2024 оны 02 сарын 05 өдрийн
А05 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



УДИРДАМЖ

2024 оны 02 дугаар сарын 05

Улаанбаатар хот

“Бүргэдийн баяр-2024” арга хэмжээг зохион байгуулах тухай

Зорилго:

Монгол улсын Засгийн газраас 2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, Улаанбаатар хотод зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор “Бүргэдийн баяр”-ын арга хэмжээг зохион байгуулна.

Хугацаа :

Бүргэдийн баярт гадаад, дотоодын жуулчид, нийслэлийн иргэд хамруулж 2024 оны 03 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд, 11:00-18:00 цагийн хооронд

Хамрах хүрээ:

Ерөнхий зохион байгуулагчид:

- Нийслэлийн Аялал жуулчлалын газар
- “Чингис хааны хүрээ” аялал жуулчлалын цогцолбор
- Баян-Өлгий аймгийн Соёл, урлагийн газар
- “Монголын бүргэчид холбоо” ТББ
- “Хушхан” ХХК

Хамтран зохион байгуулагч:

- “Баян-Өлгийн аймгийн нутгийн зөвлөл” ТББ
- “Шувуулахуй холбоо” ТББ

Дэмжигч байгууллага:

- Байгаль орчин, Аялал жуулчлалын яам
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

Арга хэмжээний хөтөлбөр,

11:00-11:30 Баярын нээлтийн үйл ажиллагаа

Зочдыг угтан авч хөтөлбөрийг танилцуулан, халуун уух зүйлээр үйлчилнэ.

11:30-12:00 Казак үндэсний урлагийн тоглолт болон ардын урлагийн тоглолт

12:00-12:10 Бүргэдтэй парад (Хамгийн сайхан үндэсний хувцастай, бүргэдтэй, морины тоноглолтой бүргэдчинг шалгаруулах)

12:10-12:30 Бүргэдчидийг танилцуулж, алдаршуулах

12:30-14:00 Бүргэдчид бүргэдээ хэрхэн сайн сургасан байдлыг шалгаруулах тэмцээн

14:00-15:00 Үдийн завсарлага

- Өдрийн хоол
- Тойром бүжиг, казак бүжгийг оролцогчидтой хамтран бүжиглэх
- Казак гэрээр зочлон казак үндэстний ахуй соёлтой танилцах
- 360 камераар зураг даруулах,
- Тэмээ унах
- Бүргэд шувуу болон тэмээтэй хамт зургаа даруулах,
- Худалдааны хэсгээр зочлон худалдан авалт хийх

15:00-15:30 Морьтон баатрын шоу тоглолт

15:30-16:30 Бүргэдчид бүргэдээр хиймэл ан бариулах тэмцээн

16:30-17:00 Тайга нохойн үзүүлбэр

Шонхор шувууны шоу тоглолт

17:00-17:30 Казак үндэсний тоглоом /Көкбар-тулам булаалдах, газраас зоос шүүрэх/

17:30-18:00 Баярын хаалтын үйл ажиллагаа

Чөлөөт арга хэмжээ:

- Зочдыг угтан авч хөтөлбөрийг танилцуулан, халуун уух зүйлээр үйлчилнэ.
- Казак гэрт, казак үндэсний дээл хувцас өмсөж зураг авхуулах.
- Казак болон гар урлалын үзэсгэлэн худалдаанд оролцож худалдан авалт хийх
- Бүргэд, харцага, шонхор шувуудтай зураг авхуулах
- 360 камераар зураг даруулах,

Анхаарах зүйлс

- Бүргэдийн баярын үеэр хурц тод өнгийн хувцас өмсөхгүй байх
- Бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх
- Зөвшөөрөлгүй дрон буюу агаарт хөөргөдөг видео камер ашиглахгүй байх
- Ил задгай хог хаяхгүй байх

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2024 оны 02 сарын 14 өдрийн
105 дугаар тушаалын 1 дугаар хавсралт

"БҮРГЭДИЙН БАЯР-2024" АРГА ХЭМЖЭЭНД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

2024 оны 02 дугаар сарын 14

Улаанбаатар хот

№	Үйл ажиллагааны төрөл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Баян-Өлгий аймаг -Улаанбаатар хот-Баян-Өлгий аймаг (ирэх, буцах тээврийн зардал)	Хүн/Өдөр 45/*2	130,000	11,700,000
2	Оролцогчдын хоолны зардал	Хүн өдөр 25*2	60,000	1,000,000
3	Хэвлэл мэдээлэл, олон нийтийн сувгаар сурталчилах, цахим сүлжээнд бүүст хийх	Өдөр 15	3,000,000	3,000,000
4	Арга хэмжээний гэрэл зураг авах, сан бүрдүүлэх	Шйрхэг	1,350,000	1,350,000
5	Урлагийн тоглолт	2*өдөр	3,000,000	3,000,000
Нийт дүн		20,050,000		